

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



Шинэ
сургалт

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭ ХЭВ МАЯГ БА БИЗНЕСИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

(Бизнесийн ахисан түвшний сургалт)

2025.09.15-17

2025 он

1) Сургалтын танилцуулга:

Тус төв нь энэ хичээлийн шинэ жилээс эхлэн зөвхөн Японд төдийгүй дэлхийд чансаагаараа тэргүүлэх нэр хүндтэй их сургуулиудын профессоруудыг урьж бизнесийн тусгай сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Энэ ажлын хүрээнд Хоккайдо их сургуулийн багш нар хүрэлцэн ирж, Монгол компаниудад бизнесээ өргөжүүлэхэд нэн шаардлагатай практик мэдлэг болох “Менежментийн шинэ хэв маяг ба бизнесийг төрөлжүүлэх стратеги” сэдвээр сургалт зохион байгуулахаар болоод байна.

Зорилго:

- ✓ Бизнесийн удирдлагын өнцгөөс диверсификаци (Бизнесээ төрөлжүүлэх стратеги) яагаад чухал болохыг ойлгох
- ✓ Өөрийн компанийн үнэ цэнийг дахин тодорхойлж, бусад салбарт хэрхэн ашиглах боломжийг судлах
- ✓ Хэрэглэгчийн өнцгөөс шинэ үнэ цэнэ бүтээж, төрөлжүүлэх стратегийн хувьд төлөвлөх

Хүлээгдэх үр дүн:

- Бизнесийн удирдлагын онолын үүднээс диверсификаци (Төрөлжүүлэх стратеги) нь ямар ач холбогдолтой, ямар зорилготой болохыг тодорхой, ойлгомжтойгоор тайлбарлах чадвартай болох
- Компанийнхаа ялгарч буй гол онцлог, давуу тал юу болохыг нягталж, тэрхүү үнэ цэнийг огт өөр, шинэ салбарт хэрхэн ашиглах боломжтойг олж харах
- BMC, STP, 4P зэрэг хэрэгслүүдийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээг сайтар ойлгож, тэдэнд зориулсан шинэ үнэ цэнийг бий болгох аргачлалд суралцах
- Компанийнхаа “дараагийн том алхам”-ыг илтгэл (pitch) хэлбэрээр бэлтгэж, танилцуулах чадвартай болох

2) Хугацаа: 2025.09.15-17 (Даваа-Лхагва, 09:30-14:00)

3) Хамрагдах хүн: Одоогийн явуулж буй үйл ажиллагаагаа тэлэн шинэ салбарт бизнесээ эхлүүлэхээр төлөвлөж буй компанийн захирлууд, удирдах ажилтнууд

4) Хамрагдах хүний тоо: 30 хүн

※Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

5) Сургалтын төлбөр: 216,000 төгрөг

6) Хичээл заах багш: Шиина Нозоми (Ph.D)



Хоккайдогойн их сургуулийн Аж үйлдвэр, академи, орон нутгийн хамтын ажиллагааг дэмжих байгууллагын Онцгой эрх бүхий дэд профессор
2008 онд Хоккайдогойн их сургуулийн Анагаах ухааны сургуулийн Эрүүл мэндийн тэнхимийг төгссөн. Яаралтай тусламжийн эмнэлэгт ажиллахын зэрэгцээ бизнесийн удирдлагын магистрын зэрэг (MBA) хамгаалсан.

2014 онд Recrit Career компанийн борлуулалтын хэлтэст ажиллаж, Отарүгийн Худалдааны их сургуулийн цагийн багшаар ажиллаж байгаад,

2020 оноос Хоккайдогойн их сургуулийн Аж үйлдвэр, академийн хамтын ажиллагааг дэмжих байгууллагад ажиллах болсон. Тус байгууллагадаа Хоккайдогойн бүс нутгийн их сургуулиудад **энтрепренёршип (entrepreneurship)** буюу **бизнес эрхлэх сэтгэлгээг төлөвшүүлэх** чиглэлээр ажиллаж байна.

Мөн 2016 онд Хоккайдод тусгайлан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, SNS маркетинг хийдэг K Project LLC зэрэг компаниудыг үүсгэн байгуулсан.

<https://researchmap.jp/nozomishiina>

Хичээл заах багш: Сато Дайсүкэ (Ph.D)



Хоккай Гакүэн Их Сургуулийн профессор (Бизнесийн удирдлагын тэнхим, Бизнесийн удирдлагын ахисан түвшний хөтөлбөр)

Мөн Карьер дэмжих төвийн захирал,

Бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих байгууллагын менежер

Осака мужид төрсөн. Кобэгийн их сургуулийн Бизнесийн удирдлагын сургуулийн докторын хөтөлбөрийг төгссөн. Бизнесийн удирдлагын доктор. 2002 оноос Хоккай Гакүэн Их Сургуульд “Бизнесийн удирдлага” зэрэг хичээлүүдийг зааж, 2012 оноос профессор болсон. Тэрээр бизнесийн удирдлага, менежмент, маркетинг чиглэлээр мэргэшсэн. “Ойлголтын менежмент” сэдвийн хүрээнд судалгаа хийдэг. Судалгааны лабораторид компани болон бүс нутгийн асуудлыг шийдвэрлэх төслүүдээс гадна оюутнуудын бизнес эрхлэх хөтөлбөр, стартапыг дэмжих зэрэг ажлуудыг хэрэгжүүлдэг. Түүний гол бүтээлүүдэд “Бүтээлч сэтгэлгээ”-г хөгжүүлэх боловсрол ба менежмент (Dobunkan Publishing) (редактор)” ба “Хүнийг хөдөлгөх менежмент (Natsume Co., Ltd.)” болно.



<Нийгмийн үйл ажиллагаа>

Газар, дэд бүтэц, тээврийн яамны Хоккайдогойн бүс нутгийг хөгжүүлэх товчооны – “Ёс зүйн гуравдагч этгээдийн хороо”-ны гишүүн,

Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны Хоккайдогойн эдийн засгийн товчооны “Бизнес эрхлэх болон бусад төслийг дэмжих зөвлөл”-ийн дарга,

Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны Хоккайдогойн эдийн засгийн товчооны “Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хүний нөөцийг бэхжүүлэх болон бусад төслийг дэмжих” хяналтын зөвлөлийн дарга,

Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны Хоккайдогойн эдийн засгийн товчооны “Япон брэндийг хөгжүүлэх болон бусад төслийг дэмжих” хяналтын зөвлөлийн дарга болон бусад

7) Сургалтын хөтөлбөр:

Өдөр	Агуулга	Цагийн хуваарь
9 сарын 15 /Даваа/	- Удирдлагын өнцгөө өөрчилж, шинэ бизнес эхлүүлэх шаардлага ○ Бизнес эрхлэх ба бизнесийн удирдлага: Бизнес гэж юу вэ? (Хүмүүсийг хөдөлгөх хүч) ○ Яагаад шинэ бизнес хэрэгтэй вэ?: (Инновацийн онол ба бүтээгдэхүүний амьдралын мөчлөг) ○ Өөрийн компанийн “энгийн зүйлс”-ийг эргэн харах - Бизнесийн загварын шинжилгээ ○ Бизнесийн загварын канвас (BMC) ашиглан одоогийн бизнесийн үйл ажиллагаагаа дүрслэн харуулах. ○ Өөрийн компанийн онцлог болон давуу талыг хэлэлцэн, хуваалцах (VRIO × нөөцийн карт). ○ Дэлхийн томоохон чиг хандлагыг мэдэж, бизнесийн боломжуудыг эрэлхийлэх.	Хичээлийн цаг 09:30-14:00
9 сарын 16 /Мягмар/	- Хэрэглэгчийн хэрэгцээг гүнзгийрүүлэн судалж, үнэ цэнийг дахин тодорхойлох ✓ Хэрэгцээг задлан шинжлэх — Хэрэглэгчид юу худалдан авдаг вэ? ○ Хэрэглэгч үнэндээ “юуг” худалдан авч байна вэ? (Хэрэгцээний шинжилгээ) ○ Өөрийн компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний “мөн чанар”-ыг олж харах ○ Бизнесээ дахин тодорхойлж, тогтвортой бизнес болгох - Шинэ бизнесийн санааг боловсруулж, илэрхийлэх нь ✓ Бүтээгдэхүүний сонирхол татахуйц байдлыг илэрхийлэх ○ Бүтээгдэхүүний үнэ цэнэ, утгыг олж харах (Ухаалаг үнэ цэнэ ба сэтгэл хөдлөлийн утга) ○ Хэрхэн хэрэглэгчдэд сонгогдож, үнэнч хэрэглэгчтэй болох вэ? ○ Бүтээгдэхүүний сонирхол татахуйц байдлыг үр дүнтэйгээр илэрхийлэх арга ба ухаалаг алхмууд	Завсарлага 10:50-11:00 /10 мин/ 12:20-12:40 /20 мин/
9 сарын 17 /Лхагва/	- Синержи зураглал ✓ Шинэ бизнес болон синержиг хэлэлцэх воркшоп ○ BMC-ыг ашиглан одоогийн болон шинэ бизнесийн санаагаа харьцуулах ○ Үнэ цэнэ бүхий төсөл болон хэрэглэгчдэд хүрэх сувгуудад синержи байгаа эсэхийг судлах - Нийтлэг нөөц боломжууд (Жишээ	

	нь: ажиллах хүч, борлуулалтын суваг, хэрэглэгчийн бааз) - Ашиглаж болох туршлага, мэдлэг (Жишээ нь: мэдээллийн технологийн үр ашигтай байдал, брэндингийн чадвар) - Эрсдэлүүд (Жишээ нь: хуучин бүтээгдэхүүний борлуулалтыг шинэ бүтээгдэхүүн “идэх” эрсдэл - канибализаци, мэдлэг дутмаг байдал г.м.) - Илтгэл (Pitch) тавих, үнэлгээ ○ Өөрийн компанийн “дараагийн том алхам”-ыг илтгэл хэлбэрээр танилцуулах ○ Бусдаас ирсэн санал хүсэлт, шүүмжийг тусган бизнесийн санаагаа улам боловсронгуй болгох - Дүгнэлт, асуулт хариулт, гэрчилгээ гардуулах	Хичээлийн цаг 09:30-14:00 Завсарлага 10:50-11:00 /10 мин/ 12:20-12:40 /20 мин/
--	---	--

8) Гэрчилгээ: Сургалтдаа ирц бүрэн хамрагдсан оролцогчдод гэрчилгээ олгоно.

9) Бүртгэл: Доорх QR кодыг уншуулж бүртгүүлнэ үү.



10) Холбоо барих:



Утас: 7511-0879(Ext.3) , 8063-0879

И-Мэйл: business@japan-center.edu.mn



Цахим хуудас: www.japan-center.edu.mn



Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/Mojc.business>

